**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН**
**/2022.06.13- 2022.06.17/**

2022.06.17 Дархан-Уул аймаг

| № | Ажлын чиглэл | Үйл ажиллагааны гүйцэтгэл |
|---|---|---|
| | | **Барилга хот байгуулалтын хэлтэс** |
| 1 | Барилгын материал үйлдвэрлэл, лобараторийн чиглэл | Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022.04.12-ны өдрийн 01-А/96 захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж орон нутгийн өмчит 95 байгууллагын 245 газар эзэмших эрх болон газрын суурь үнэлгээг 2021 оны санхүүгийн тайланд үнэлсэн үнэлгээг 2022.05.10-.2022.05.30-ны хооронд шалгаж тооллоо. 245 газраас 88 газрын 33.6 тэр бум төгрөг /33 649 044 400/-ийн зөрчлийг илрүүлж ажилласан.<br>Үүнээс Санхүүгийн тайланд **дутуу** үнэлж оруулсан 75 газрын 9.1 тэр бум төгрөг /9 064 097 400/, **илүү** үнэлсэн 13 газрын 24.5 тэр бум төгрөг /24 584 947 000/-ийн зөрчил гарсан. Мөн 237 барилга байгууламжийн ашиглалтанд орсноос хойш хувийн хэрэг хөтлөлт, газрын гэрчилгээний цахим код авч шинэчилсэн эсэх, газрын кадастрт барилга байгууламжийн бүртгэл зэргийг хянаж шалгаж ажилласан. Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөлт маш муу, зарим барилгад хувийн хэрэг нээгээгүй, барилга нь газар эзэмших эрхийн гэрчилгээний кадастрт ороогүй зөрчлүүд байсан. Эдгээр зөрчлийг арилгах зааварчилгаа өгч зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтээр тухайн газрууд гэрээ гэрчилгээг шинэчлэн ажилласан байна. Мөн санхүүгийн тайланд тусгаагүй газрууд газрын төлбөр төлдөггүй, зарим нь ийм газартайгаа мэдэхгүй байсан.<br>✓ Эх үүсвэр: МУЗГын 2018 оны 182 тогтоол, БХБСайдын 2018 оны 208 тушаал, ДУАИТХ 2018 оны 08/01 тогтоолыг үндэслэн үнэлгээг тооцсон. |
| 2 | Инженерийн дэд бүтцийн чиглэлээр | ✓ Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилга ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2 барилгад олгосон. Үүнд:<br>- Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1-р баг, иргэн Т.Наранчимэгийн жуулчны баазын цэвэр усны худгийн 6кВ цахилгаан дамжуулах шугам<br>- Орхон сумын 1-р баг иргэн Ж.Отгонбаатарын төмс, хүнсний ногооны усалгаатай тариалангийн зориулалттай газрын цахилгаан хангамж<br>- Орхон сумын 1-р баг иргэн К.Мягмарсүрэнгийн төмс, хүнсний ногооны усалгаатай тариалангийн газрын цахилгаан хангамж<br>✓ Барилга хот байгуулалтын сайдын хэрэгжилтийг нэгтгэж ХБТХОХ-т хүргүүлсэн.<br>✓ Хонгор сумын Зулзагын голын авто замын барилга угсралтын ажилтай холбогдуулан цахилгааны шугам чөлөөлөх талаар хуралд оролцсон.<br>✓ АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй МОН9206 төслийн баг Дархан суманд ажиллахтай холбогдуулан ирсэн төлөөлөлтэй уулзаж угсралтын ажлыг танилцуулсан. |
| | | **Газрын удирдлагын хэлтэс** |
| 2 | Геодези, зураг зүйн чиглэл | Хаягийн зургийн дагуу 8 иргэн, 5 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.<br>Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт / хэмжилт хийлгэсэн 14 иргэн, 0 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан.<br>Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн 2 иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн.<br>Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Гео од", "Ёлт сүрвэй" ХХК-ний хийж гүйцэтгэсэн барилга байгууламж, зам, талбай, инженерийн шугам сүлжээний 9 улаан шугам, 3 гүйцэтгэлийн зургийг хзлээж авсан.<br>GNSS-ийн байнгийн ажиллагаатай стацад тулгуурлан GPS-ийн сүлжээний 704, 5707, 012, 5480 цэгүүд дээр |

| | | |
|---|---|---|
| | | бодит агшины RTK хэмжилт хийж гүйцэтгэн хэмжилтийн үр дүнг 192.168.20.24 /Geodesy/ GNSS Дархан хавтсанд байршуулж, албан бичгээр хүргүүлсэн.<br>Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шалгагдаж байгаа гэмт хэргийн бүртгэлийн 272, 606 дугаартай гомдол мэдээлэлд өгөгдсөн цэгийн байршлыг харуулсан зургийг гаргаж албан бичгээр хүргүүлсэн. |
| 3 | Газрын татвар, төлбөр үнэлгээ | |
| **Захиргаа аж ахуйн чиглэл** | | |
| 1 | Хүний нөөц, дотоод асуудал, хууль эрх зүй | Шүүх хурлын мэдээлэл:<br>✓ “Алтантүрүү” ХХК-ны нэхэмжлэлтэй ГХБХБГ-т холбогдох иргэний хэргийн шүүх хуралдааныг нэхэмжлэгч талаас өмгөөлөгч Б.Содболд нь өмгөөлөх эрхээсээ татгалзаж, нэхэмжлэгч тал хөдөө байгаа тул дахин 7 хоногоор хойшлуулах хүсэлт гаргаж, 2022/06/22-нд 09:00 цагт хуралдахаар шийдвэрлэсэн.<br>✓ Альфа констракшн ХХК-ны нэхэмжлэлтэй ГХБХБГ-т холбогдох захиргааны шүүх хуралдааныг 2022/06/24-ны өдрийн 10:00 цагт хуралдахаар шийдвэрлэсэн.<br>✓ Бадрал Өргөө ХХК-ны нэхэмжлэлтэй аймгийн ЗДаргад холбогдох захиргааны шүүх хуралдааныг 2022/06/23-ны өдрийн 10:00 цагт хуралдахаар шийдвэрлэсэн.<br>✓ Улаанбаатар менежмент ХХК-ны нэхэмжлэлтэй аймгийн ЗДаргад холбогдох захиргааны шүүх хуралдааныг 2022/06/28-ны өдрийн 10:00 цагт хуралдахаар шийдвэрлэсэн<br>Сургалт:<br>✓ Д.Өлзийбаатар /Ph.D/ сургагч багшийн “Монголчууд 20 дугаар зуунд” сэдвээр ТАЗөвлөлөөс цахимаар зохион байгуулагдсан 7:4:10 сургалтад 3 албан хаагч оролцсон.<br>✓ “Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн ур чадварыг дээшлүүлэх” цахим сургалтад 2 албан хаагч хамрагдсан.<br>Сонсох ажиллагаа: ЗЕХ<br>✓ Захиргааны шийдвэр гаргах ажиллагаатай холбогдуулан Сонсох ажиллагааны мэдэгдлийг 3 иргэн, хуулийн этгээдэд шуудангаар хүргүүллээ.<br>Хүний нөөц:<br>✓ 2021 онд тусгай шалтгалтын дагуу ТАСЗөвлөлийн 71,72,73 дугаар тогтоолын дагуу томилогдсон 3 албан хаагчдын Тангараг өргүүлэх материалыг аймгийн ТАСЗөвлөлд хүргүүлхээр ажиллаж байна.<br>✓ ОХУ-ын Якут хот дахь Хөдөө аж ахуйн их сургуулин 3 дугаар дамжааны оюутан Б.Хасхүүг мэргэжилтэн Б.Баярмаагийн удирдлага дор үйлдвэрлэлийн дадлага хийлгүүлхээр газрын даргын тушаалыг боловсруулсан. |
| 2 | Мэдээллийн технологи, нярав | **Мэдээлэл:**<br>Байгууллагын 70376471 нээлттэй утсаар 5, Facebook хуудсанд ирсэн 7 иргэний асуултанд хариулт өгөв.<br>Дархан сумын 8-р багт байрлах гаражуудын нэгж талбарын хувийн хэргийн баяжуулалтыг хийлээ.<br>**Мэдээлэл технологийн чиглэлээр:**<br>Байгууллагын цахим хуудасны нээлттэй ажлын байр хэсэгт болон Facebook хуудсанд Архив, бичиг хэргийн ажилтан ажилд авах тухай зар байрлуулав.<br>Серверийн өрөөний кондишны илүүдэл усыг асгаж цэвэрлэв.<br>ГЗБГЗЗГазар руу байгууллагын компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмжийн судалгааг гаргаж цахим шуудангаар болон албан тоотоор илгээв.<br>**Нярав:**<br>Кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 16 ширхэгийг хүлээж авч бүртгэв.<br>Шаардах хуудсаар 3 төрлийн 20 ширхэг бараа материал олгов. |

Тайлан боловсруулсан:

Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Золбаясах

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга Г.Нямдорж